



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 537

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Замын-Үүдийн дулааны станц” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 17 нэрийн, нийт 72,629,822.90 (далан хоёр сая зургаан зуун хорин есөн мянга найман зуун хорин хоёр төгрөг ерэн мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Замын-Үүдийн дулааны станц” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал О.Төмөрхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Акталж данснаас хасах хөрөнгөөс төмрийн хаягдлыг ялган тоолж “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” төрийн өмчит хувьцаат компанид тушаах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2022 оны 11 дүгээр сарын-ны өдрийн
 дугаар тогтоолын хавсралт

"Замын-Үүдийн дулааны станц" төрийн өмчит үйлдвэрийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,
 акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөгөөр)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)
1	Гүний өрөмдлөгийн худаг СКВ-11	2000.01.31	ш	1	11,200,000.00	11,200,000.00
2	Зэхэлтийн шугамын холболт - УТШС	1997.12.31	ш	1	20,797,501.00	20,797,501.00
3	Зурагт	2009.12.30	ш	1	1,111,240.90	1,111,240.90
4	Шкаф төмөр хувцасны 8 хаалгатай	2017.02.08	ш	2	171,644.00	343,288.00
5	Сейф жижиг хүндрүүлэгчтэй	2014.06.04	ш	1	117,400.00	117,400.00
6	Компьютер суурин Dell Core i3	2016.01.01	ш	1	1,380,500.00	1,380,500.00
7	Компьютер суурин Dell Core i3 CPU 4RAM 4GB	2015.08.10	ш	1	1,010,000.00	1,010,000.00
8	Принтер Samsung ML-2165W	2015-08-10	ш	1	120,000.00	120,000.00
9	Мотоцикл DAYUN 150/5	2014.02.02	ш	1	754,740.00	754740
10	Зуухны яндан цэцэрлэг	2013.01.01	ш	1	9,510,650.00	9,510,650.00
11	Зуух КВР-012-95 цэнхэр	2017.03.11	ш	1	7,000,000.00	7,000,000.00
12	Тогоо /төв уурын зуух/ БЗУИ-100	2004.05.01	ш	1	16,183,343.00	16,183,343.00
13	Сүлжээний хайрцаг тоноглолтой	2018.06.01	ш	1	1,485,000.00	1,485,000.00
14	Домайн пост	2018.01.01	ш	1	233,080.00	233,080.00
15	Архивын программ	2018.01.01	ш	1	300,000.00	300,000.00
16	Вэб хуудас	2015.11.03	ш	1	223,080.00	223,080.00
17	Вирусын программ Kaspersky	2020.07.20	ш	1	860,000.00	860,000.00
						72,629,822.90
Нийт дүн						(далан хоёр сая зургаан зуун хорин есөн мянга найман зуун хорин хоёр төгрөг ерэн мөнгө)